

ЗУРГААН НАСТАЙ ХҮҮХДИЙН СЭТГЭХҮЙН ЗАДЛАН ШИНЖИЛЖ, НЭГТГЭН ДҮГНЭХ ҮЙЛДЛИЙГ СУДАЛСАН ҮР ДҮН

О.Тунгалаг, доктор, МУБИС

Abstract: We selected the analysis method processed by L.A. Yasyukova, a Russian psychologist, in order to study psychological actions of 6 year-old students. We adapted the method based on the psychological features of Mongolian children.

This research method analyzes the psychology of 6 year-old students and determines their intellectual quality and how they are prepared for the school attendance. Totally 305 students from rural and urban areas were participated in our research work.

This article introduces the results of the research on young children, whose psychology is developed insufficiently. It is revealed that outer shape, type, characteristics, daily skills and custom of their lives directly impact on the intellectual and psychological quality of the children.

Түлхүүр үг: сэтгэхүй, сэтгэхүйн задлан нэгтгэх үйлдэл, сэтгэх чадвар, сэтгэхүйн хэв шинж.

Удиртгал

Ерөнхий боловсролын сургуульд зургаан настай хүүхдийг 2008-2009 оны хичээлийн жилээс элсүүлэн сургаж эхэлсэнтэй холбоотойгоор зургаан настай хүүхэд бие сэтгэц, нийгэмшихүйн хувьд сургуульд бэлтгэгдсэн байх шаардлага бий болж байна. Тиймээс хүүхдийн хөгжлийг зөв удирдах, тэд амжилттай суралцах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тэдний сэтгэцийн хөгжлийг судлан, ялангуяа сургалтад хамгийн гол шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх танин мэдэхүйн үйл болох сэтгэхүйн хөгжлийг судалж, хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ үүднээс бид 6 настай хүүхдийн сэтгэхүй задлан шинжилж, нэгтгэн дүгнэх үйлдлийг ОХУ-ын сэтгэл зүйч Л.А.Ясюковагийн боловсруулсан арга зүйгээр тандан судласан юм.

Уураг тархины дээд бүтээгдэхүүн сэтгэхүй нь хүүхдийн танин мэдэхүйн болон практик ажиллагаа, сургалт хүмүүжлийн явцад хөгждөг болохыг эрдэмтэд олж тогтоосон билээ. Зургаан настай хүүхдийн сэтгэхүй бусад насны хүүхдийн нэгэн адил бодит үйлдлээс бодит дүрслэлд, үүнээсээ хийсвэр сэтгэхүй рүү шилжин хөгжиж байдаг зүй тогтолтой гэж үздэг. Тэд бодит дүрс, загваруудад тулгуурлан сэтгэнэ. Ингэхдээ энгийн ухагдахуун, бодит юмсыг жиших, харьцуулах,

төрөлжүүлэх, бүлэглэх, задлан шинжлэх зэрэг сэтгэхүйн энгийн арга барилыг эзэмшиж байдаг. Энэ үед хүүхэд юмс үзэгдлийн гадаад төрх байдлаас дотоод мөн чанар руу шилжиж, улмаар түүний сэтгэхүйн хөгжилд чанарын өөрчлөлт гарч эхэлнэ (Санжжав, 2013, х.10).

Сэтгэл судлаач Ж.Пиаже хүүхдийн оюун ухааны хөгжлийг өөр өөр шинж чанартай дөрвөн үе шат болгон судалж, улмаар оюун ухааны хөгжлийн онол боловсруулсан байдаг. Үүнд:

1. Хүртэхүй-хөдөлгөөний үе (0-2 нас)
2. Үйлдэл төлөвшихийн өмнөх үе (2-7 нас)
3. Тодорхой үйлдлийн үе (7-11 нас)
4. Формаль үйлдлийн үе (12-оос дээш)

Бидний судалгаанд хамрагдсан 6 настай хүүхдүүд оюун ухааны хөгжлийн хоёр дахь үе болох үйлдэл төлөвшихийн өмнөх үе шатанд хамрагдаж байна. Хөгжлийн энэ үед хүүхэд өөрөө ярьж, оюун ухааны үйлдэл хийж, ертөнцийг танин мэддэг гэж Ж.Пиаже үзжээ (2001, х.75). Үйлдэл төлөвшихөөс өмнөх үеийн хүүхдийн сэтгэхүй нь дараах хэд хэдэн онцлогтой. Үүнд: Энэ шатны хүүхдүүд юмыг төдий л сайн хийсвэрлэн сэтгэж чаддаггүй. Тэдний оюун ухаанд “энд ба одоо” гэсэн үйл зонхилдог. Биет объектуудыг тэд тун хялбархан ойлгоно. Өөрөөр хэлбэл юмсын хоорондын холбоог дүрслэн сэтгэх чадвар сайн биш. Энэ насны хүүхдийн бас нэг онцлог бол “өөр дээрээ төвлөрүүлэн” сэтгэх чадвар давамгайл байдаг. Тэдний алсыг харах хүрээ нь хязгаарлагдмал, учир нь тэд хүмүүсийн өөр өөр санаа бодлыг анхааралдаа хүлээн авч, нарийвчлан задлан шинжлэх чадвар дутмаг байдаг байна (2001, х.367-368).

Мөн Л.А.Венгер, В.С.Мухина нар 6 настай хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн нэг ололт бол хүүхэд ямар нэг зүйлийг тогтоохын тулд олон удаа давтах, тогтоох зүйлийг өөрийн мэддэг зүйлтэй холбож дүрслэх зэрэг аргыг хэрэглэж эхэлдэг гэж үзжээ (Ичинхорлоо, 2009, х.18).

Бид нэгдүгээр ангийн сурагчдын сэтгэх чадварын онцлогийг судлахдаа сэтгэл зүйч Л.А.Ясюковагийн боловсруулсан харж задлан нэгтгэх арга зүйг ашиглав. Даалгаврын үр дүнг боловсруулахдаа зөв хариулт бүрд 1 оноо өгнө. Нийт 4 оноо авах ёстой. Харин хариулт буруу бол

0 оноо буюу ойлгож сэтгэхийн өмнөх үе шатанд байна гэж үзнэ.

Бидний судалгаанд хот, хөдөөгийн нэгдүгээр ангийн нийт 305 сурагч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан сурагчдын харж задалж нэгтгэх сэтгэх

чадварын дундаж ($\bar{X}$), дунджийн алдаа (m), квадрат хазайлт (σ), вариацийн коэффициент (Vc) зэрэг тоон үзүүлэлтийг дараах хүснэгтээр үзүүлэв.

**Зургаан настай сурагчдын харж
задлан-нэгтгэн сэтгэх чадварын түвшин**

Хүснэгт 1
Сурагчдын тоо 305

Даалгавар	Статистик үзүүлэлтүүд	Min- Max	$\bar{X}$		m	σ	Vc
			оноо	%			
Харж задлан -нэгтгэх		,00- 4,00	1,3770	32,5	0,05	,9487	,900


Дээрх хүснэгтээс ажиглахад зургаан настай сурагчдын юмсыг задлан-нэгтгэх болон зүй тогтлыг олох чадварын түвшин дунджаар 1,37 оноо буюу нийт даалгаврынхаа 32,5%-ийг гүйцэтгэх чадвартай нь тогтоогдлоо. Энэ нь тийм сайн үзүүлэлт биш нь ойлгомжтой. Учир нь бидний судалгаанд хамрагдсан 6 настай 300 гаруй сурагчид юмыг задлан шинжилж нэгтгэн сэтгэх чадвар ерөнхийдөө хангалтгүй хөгжсөн болох нь тодорхой харагдаж байна. Өөрөөр хэлбэл, тэд сургуульд элсэхдээ сэтгэхүйн хувьд бэлтгэл хангалтгүй орж иржээ гэх дүгнэлтэд хүргэж байна. Харин хувь сурагч бүр даалгаврыг гүйцэтгэсэн байдал харилцан адилгүй байгаа нь дээрх хүснэгтийн min- max (0,00-4,00) баганаас тодорхой байна. Ингээд хувь сурагчдын сэтгэхүйн задлан-нэгтгэх үйлийн даалгавар гүйцэтгэсэн байдлын давтамжийг доорх хүснэгтээс авч үзье.

Зургаан настай сурагчдын харж задлан-нэгтгэн сэтгэх чадвар (давтамж, хувиар)

Хүснэгт 2

Оноо	Давтамж (f)	Хувь
00	55	18,0
1,00	124	40,7
2,00	84	27,5
3,00	40	13,1
4,00	2	,7
Нийт	305	100,0

Диаграмм 1



Дээрх хүснэгт, диаграммаас ажиглахад судалгаанд хамрагдсан сурагчдын 68,2% нь 1-2 даалгаврыг, 13,8% нь 3-4 даалгаврыг зөв гүйцэтгэсэн бол нэг ч даалгавар зөв гүйцэтгэж чадаагүй буюу 0 оноо авсан сурагчид 18%-ийг тус тус эзэлж байна. Эдгээр 0 оноо авсан сурагчид нь сэтгэхүйн задлан шинжилж нэгтгэх үйлдэл хийх даалгаврыг буруу гүйцэтгэсэн бөгөөд ойлгож сэтгэхийн өмнөх үед байгаа тул тэдний сэтгэхүй хангалтгүй хөгжжээ гэж үзнэ. Гэхдээ энэ хэв шинж бүхий сурагчдыг ажиглахад сэтгэхүйн тухайн даалгавруудыг хэдийгээр буруу гүйцэтгэж, буруу сэтгэн бодож байсан хэдий ч, ойлгон зөв сэтгэн бодох хэмжээнд дөхсөн олон янзын боломжийн хувилбарууд гарган, янз бүрийн зүйлд тулгуурлан сэтгэн бодох оролдлогууд хийж байлаа. Энэ бүгдээс үүдэн 0 оноо авсан ойлгож сэтгэхийн өмнөх хэв шинжийн сурагчдын сэтгэх чадварын онцлогт анализ хийх шаардлага гарч ирсэн юм. Ингээд тэдний ойлгож сэтгэхийн өмнөх хэв шинжийн онцлогт задлан шинжилгээ хийх үүднээс дараах даалгавар зургууд дээр тулгуурлан авч үзье:

Харж задлан-нэгтгэн сэтгэх чадварын даалгаврууд



Харж задлан- нэгтгэн сэтгэх даалгаврын:

- Эхний эгнээний зургаас зөв хариулт нь “нохой”. Харин хүүхдүүд “зараа” болон “туулай”-ны зургийг сонгож, яагаад бусдаасаа өөр буюу илүү гэж үзсэн тухайгаа тайлбарлахдаа “туулай аймхай”, “зараа -өргөстэй, хатгадаг” учраас гэж хариулсан. Энэ нь нилээд мэдрэмжтэй, сэтгэлийн хөдөлгөөн, хөөрөл ихтэй, сурагчдад давамгайлалдэг онцлогтой болох нь тогтоогдлоо. Энэхүү сурагчид нь тухайн үзэгдлийн гол шинжид нь биш харин сэтгэлийн хөдөлгөөндөө хөтлөгдөж хамгийн тод ялгарч байгаа шинжүүдэд нь тулгуурлан сэтгэж сонголтыг хийдэг бөгөөд ойлгож сэтгэхийн өмнөх сэтгэл хөдлөлөөр дүрслэн сэтгэх хэв шинжийн сурагчид байлаа.

- Хоёрдах эгнээний зургаас зөв хариулт нь “цэцэг”. Тухайн эгнээнээс “хутга”-ны зургийг бусдаасаа өөр буюу илүү гэж үзэн, сонгохдоо “хутганы гадна талд цэгүүд байхгүй байна” гэж тайлбарласан сурагчид нь эд юмсын харагдаж байгаа гадаад шинжүүдэд баримжаалан дүгнэлт

хийсэн учраас харагдахгүй байгаа гол шинжүүдийг ялгаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл эд юмсын хэлбэр, өнгө, дүрс зэрэг харагдаж байгаа гадаад шинжүүдийг чухал шинж болгон ашиглаж байгаа бөгөөд ойлгож сэтгэхийн өмнөх гадаад шинжид тулгуурлан сэтгэх хэв шинжийн онцлог илэрч байна.

- Гуравдах эгнээ зургаас зөв хариулт нь “талх”. Энэ эгнээнээс хүүхдүүд “тариан түрүү”, “улаан лооль, өргөст хэмх”-ийн зургийг сонгож, тайлбарлахдаа “тариан түрүү-ургадаг”, “улаан лооль, өргөст хэмх-ногооны талбайд ургана” гэж хариулжээ. Эдгээр сурагчид сонголтыг тохиолдлын хийсвэр байдлаар хийдэг бөгөөд ойлгож сэтгэхийн өмнөх бүхэллэг болгон дүрслэн сэтгэх хэв шинжийн онцлог илэрч байв.

- Дөрөвдэх эгнээ зургаас зөв хариулт нь “цаас”. Харин хүүхдүүд “хайч”, “харандаа” гэсэн зургийг сонгоод “хайч бол хайчилдаг, зургийн хэрэгсэл биш”, “харандаа бол зурдаг, буддаг” гэж тайлбарлан зургийг сонгохдоо тухайн сурагчид

ахуйн нөхцөл байдалд хэрэглэгддэг дасал болсон, амархан танигдаж байгаа зүйлүүдийг сонгосон нь зөв хариуг олоход саад болж байна. Тухайн сонголтыг хийсэн сурагчдад ойлгож сэтгэхийн өмнөх нөхцөлөөс ургуулан дүрслэн сэтгэх хэв шинж илэрч байна.

Энэ мэтчилэн “0” оноо авсан сэтгэхүйн задлан шинжилж нэгтгэх үйлдэл сайн хөгжөөгүй гэсэн үнэлгээ авсан сурагчдын сэтгэхүйд задлан шинжилгээ хийж тэд сэтгэхүйн даалгавруудыг яагаад буруу гүйцэтгэв, нөлөөлсөн зүйл юу байв гэж үзэхэд олон хүчин зүйл нөлөөлсний заримыг бид илрүүлж чадлаа. Тодруулбал, тухайн сурагчийн сэтгэлийн хөдөлгөөн, юмс үзэгдлийн дотоод мөн чанар, зүй тогтол гэхээсээ илүү гадаад шинж тэмдэг, хэлбэр дүрсийг чухалчлах, тохиолдлын байдлаар хэт хийсвэрлэн асуудалд хандах, эсвэл ахуйн нөхцөл байдал амьдралын дадал зуршил зэрэг олон хүчин зүйлүүд тэдний сэтгэн бодох чадварын үр дүнд нөлөөлжээ гэсэн дүгнэлтэд хүрлээ.

ДҮГНЭЛТ

Зургаан настай сурагчдын харж задлан нэгтгэн сэтгэх чадвар ($\bar{X}=1,37$ буюу 34,3%) ерөнхийдөө хангалтгүй хөгжсөн байна. Гэхдээ хувь сурагч бүрийн сэтгэх чадвар харилцан адилгүй хөгжжээ.

Ойлгож сэтгэхийн өмнөх хэв шинжийн гэж нэрлээд байгаа зургаан настай сурагчдын сэтгэн бодох хэв шинж, нөлөөлөх хүчин зүйл олон янз байна. Тодруулбал, “сэтгэл хөдлөлөөр дүрслэн сэтгэх”, “нөхцөлөөс ургуулан дүрслэн сэтгэх”, “нөхцөл байдалд тулгуурлан сэтгэх”, “бүхэллэг болгон дүрслэн сэтгэх” ойлгож сэтгэхийн өмнөх хэв шинжүүд илэрч байна. Энэхүү ойлгож сэтгэхийн өмнөх хэв шинжид байгаа хүүхдүүдэд зориулсан сургалтын хөтөлбөртэй байх, үүний дагуу ялангуяа сургуулийн өмнөх наснаас нь эхлэн тэдний сэтгэхүйг хөгжүүлэх, сургуульд орох бэлтгэлийг хангах асуудлыг онцгой анхаарах шаардлагатай болох нь бидний судалгааны үр дүн харуулж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Крайг, Г. (2001). *Психология развития*. Москва
Ичинхорлоо, Ш. (2009). *6 настай хүүхдийн тухай өгүүлэх нь*. Улаанбаатар
Санжжав, Д. (2013). *Хүүхдийн нас зүй сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал*. Улаанбаатар
Тихомиров, О.К. (1984). *Психология мышления*. Москва
Цэрэндондов, П. (2006). *Оюун ухаан ба танин мэдэхүйн зарим үйл явцыг судлах арга зүй*. Улаанбаатар
Цэрэндондов, П., Чимэдлхам, Ц. (2007). *Сурган-сэтгэл зүйн судалгааны баримтад статистик задлан шинжилгээ хийх арга*. Улаанбаатар
Ясюкова, Л.А. (2007). *Методика определения готовности к школе*. СПб:ИМАТОН